

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 3 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ЧӨЛӨӨЛӨХ, ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.7, 9.2.12.8 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг /РД:МБ83120301/ нь өөрийн хүсэлтээр ажлаас гарах тухай хүсэлт гаргасан тул тус хүсэлтийг үндэслэн 2026 оны 9-р сарын 1-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал Чинзориг овогтой Тэмүдэр /РД:УХ89052659/-ийг 2026 оны 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирлаар томилсугай.
3. Б.Бадамцэцэгийн гүйцэтгэж байсан ажил үүрэг, бусад холбогдох баримт материал, эд хөрөнгийг 2026 оны 9-р сарын 1-ний өдрөөс 9-р сарын 07-ны өдрийн хооронд актаар хүлээлцэхийг Ч.Тэмүдэрт үүрэг болгосугай.
4. Компанийн гүйцэтгэх захирал өөрчлөгдөж байгаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, УБЕГ болон бусад хамтран ажилладаг байгууллагуудад мэдэгдэн, мэдээллээ шинэчлэн ажиллахыг Ч.Тэмүдэрт үүрэг болгосугай.
5. Компанийн Гүйцэтгэх захирал албан тушаалд томилогдон ажиллах Ч.Тэмүдэрт Монгол улсын хууль тогтоомж, компанийн дүрэм болон бусад холбогдох журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ